



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 03

Арвайхээр

Төрийн албан хаагчийн манлайлал,
ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт:

1.1. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бичиг баримтын нэр төрлийг цөөлөх, хялбаршуулах, цахимжуулах, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

1.2. Төрийн албан хаагчид ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах үедээ архидан согтуурах явдлыг таслан зогсоох чиглэлийн арга хэмжээг байгууллагын дотоод журам, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд нарийвчлан тусгах

1.3. Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор ажлын цагаар байгууллагын интернет ашиглан олон нийтийн сүлжээ /facebook, Youtube, Twitter, Steam, Instagram гэх мэт/-нд нэвтрэхийг хориглох

1.4. Төрийн байгууллагууд камерын хяналтын системийг бүрэн ашиглаж, ажлын байрны эмх цэгц, дэг журмыг чангатгах, цалин, урамшууллыг ажлын бүтээмж, цахим цаг бүртгэл, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанартай нь уялдуулан олгодог байх

1.5. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд улирал бүр дүн шинжилгээ хийж, асуудлын мөн чанарыг судалж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцох

1.6. Иргэдийг сум, аймаг, нийслэл рүү удаа дараа явуулж, чирэгдэл учруулсан нь төрийн албан хаагчийн буруугаас гэдэг нь тогтоогдсон бол замын зардлыг тухайн албан хаагчаар нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх

1.7. Албаны ажил хэргийг явуулахдаа өөрөөсөө зайлуулах, хариуцлагаас зайлсхийх зэрэг зохисгүй байдал гаргахгүй байж, хууль тогтоомжийн хүрээнд ажилдаа эзэн болж, удирдлагаас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнг биечлэн хариуцах

011200005

D:My Doc. Zahiramj. Zasag darga

1.8. Удирдах ажилтанд тавигдаж буй нийгмийн шаардлага, зарчмыг соргоогоор мэдэрч удирдлагын арга барилыг байнга хөгжүүлж, албан хаагчдыг зөв чиглүүлэн манлайлал, ёс зүйг өөрийн биеэр үлгэрлэх

2. Төрийн нийт албан хаагчдад:

2.1. Төрийн албан хаагч бүр манлайлагч, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээгээр ажилдаа хандах, иргэдийг үнэн зөв мэдээллээр зөвлөн чиглүүлэх, мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх зарчмуудыг нэн тэргүүнд баримтлан ажиллах

2.2. Төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, ажлын байр, байгууллагын гаднах орчин, албан хэрэгцээний унаанд болон албан үүргээ гүйцэтгэх явцдаа согтууруулах ундаа хэрэглэх явдал гаргахгүй байх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх


2.3. Төрийн албан хаагч бүр хуулийг дээдлэн сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төрийн албанд ажиллах бөгөөд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журмаар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж, хариуцлагатай чанар үр дүнтэй гүйцэтгэх

3. Албан даалгаврыг иргэд, олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд тусган, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ гол үзүүлэлт болгон дүгнэж байхыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4. Албан даалгаврын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, тайлагнахыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү албан даалгавар гарсантай холбогдуулан 2009 оны "Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай" 01 дүгээр албан даалгаврыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 03

Арвайхээр

Төрийн албан хаагчийн манлайлал,
ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт:

1.1. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бичиг баримтын нэр төрлийг цөөлөх, хялбаршуулах, цахимжуулах, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

1.2. Төрийн албан хаагчид ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах үедээ архидан согтуурах явдлыг таслан зогсоох чиглэлийн арга хэмжээг байгууллагын дотоод журам, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд нарийвчлан тусгах

1.3. Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор ажлын цагаар байгууллагын интернет ашиглан олон нийтийн сүлжээ /facebook, Youtube, Twitter, Steam, Instagram гэх мэт/-нд нэвтрэхийг хориглох

1.4. Төрийн байгууллагууд камерын хяналтын системийг бүрэн ашиглаж, ажлын байрны эмх цэгц, дэг журмыг чангатгах, цалин, урамшууллыг ажлын бүтээмж, цахим цаг бүртгэл, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанартай нь уялдуулан олгодог байх

1.5. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд улирал бүр дүн шинжилгээ хийж, асуудлын мөн чанарыг судалж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцох

1.6. Иргэдийг сум, аймаг, нийслэл рүү удаа дараа явуулж, чирэгдэл учруулсан нь төрийн албан хаагчийн буруугаас гэдэг нь тогтоогдсон бол замын зардлыг тухайн албан хаагчаар нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх

1.7. Албаны ажил хэргийг явуулахдаа өөрөөсөө зайлуулах, хариуцлагаас зайлсхийх зэрэг зохисгүй байдал гаргахгүй байж, хууль тогтоомжийн хүрээнд ажилдаа эзэн болж, удирдлагаас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнг биечлэн хариуцах

011200005

D:My Doc. Zahiramj. Zasag darga

1.8. Удирдах ажилтанд тавигдаж буй нийгмийн шаардлага, зарчмыг соргогоор мэдэрч удирдлагын арга барилыг байнга хөгжүүлж, албан хаагчдыг зөв чиглүүлэн манлайлал, ёс зүйг өөрийн биеэр үлгэрлэх

2. Төрийн нийт албан хаагчдад:

2.1. Төрийн албан хаагч бүр манлайлагч, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээгээр ажилдаа хандах, иргэдийг үнэн зөв мэдээллээр зөвлөн чиглүүлэх, мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх зарчмуудыг нэн тэргүүнд баримтлан ажиллах

2.2. Төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, ажлын байр, байгууллагын гаднах орчин, албан хэрэгцээний унаанд болон албан үүргээ гүйцэтгэх явцдаа согтууруулах ундаа хэрэглэх явдал гаргахгүй байх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх


2.3. Төрийн албан хаагч бүр хуулийг дээдлэн сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төрийн албанд ажиллах бөгөөд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журмаар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж, хариуцлагатай чанар үр дүнтэй гүйцэтгэх

3. Албан даалгаврыг иргэд, олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд тусган, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ гол үзүүлэлт болгон дүгнэж байхыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4. Албан даалгаврын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, тайлагнахыг сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү албан даалгавар гарсантай холбогдуулан 2009 оны "Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай" 01 дүгээр албан даалгаврыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД